



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 01/47

Улаанбаатар хот

2010 онд мөрдөх “Хүн амын амьжиргааны  
доод түвшин”-г тогтоох тухай

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШЛАХ нь:

Нэг. “Хүн амын амьжиргааны 2010 оны доод түвшин”-ий хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталж 2010 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлсүгэй.

Хоёр. Шинэчлэн баталсан “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий хэмжээг холбогдох байгууллагад албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН